



**МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН
ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 2021-2024 ОНЫ
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

УЛААНБААТАР, 2025

МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, гуравдугаар хавсралтаар “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тус тус баталсан.

Тус бодлогын баримт бичигт Үндэсний нэгдмэл үнэт зүйл, Хүний хөгжил, Амьдралын чанар ба дундаж давхарга, Эдийн засаг, Засаглал, Ногоон хөгжил, Амар тайван аюулгүй нийгэм, Бүс, орон нутгийн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот гэсэн үндсэн 9 зорилгын хүрээнд 47 зорилт дэвшүүлж, 243 арга хэмжээ, хяналт-шинжилгээ, үнэлгээний 95 шалгуур үзүүлэлтийг тусгасан.

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг төрийн байгууллагууд тайлагнасан байдлыг үзэхэд, 115 арга хэмжээний хэрэгжилтийг өссөн дүнгээр, 106 арга хэмжээний биелэлтийг тухайн жилийн буюу 2024 оны хэрэгжилтээр, 22 арга хэмжээний хэрэгжилтийг 2023-2024 оны дүнгээр тайлагнасан байгаа тул тухайн жилийн хэрэгжилтийг өмнөх онуудын хэрэгжилттэй харьцуулан хянах байдлаар өссөн дүнг тооцож, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг 2021-2024 оны дүнгээр болон зорилго тус бүрээр танилцуулбал:

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн нийт 9 зорилго, 47 зорилтыг хангахад чиглэсэн 243 арга хэмжээний хэрэгжилт дунджаар 67.0 хувь байна. Энэ нь 2024 оны хэрэгжилтээс 0.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


Нийт арга хэмжээний 10.7 хувь буюу 26 арга хэмжээ “үр дүнтэй”, 51.9 хувь буюу 126 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 33.3 хувь буюу 81 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай”, 4.1 хувь буюу 10 арга хэмжээ “үр дүнгүй” үнэлэгдсэн байна.

Хүснэгт 1. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт (үндсэн 9 бодлого, хэрэгжилтийн хувиар)

№	Бодлого/Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь				Дундаж үнэлгээ
				Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
				100.0	90.0-70.0	69.0-30.0	29.0-0.0	
1	Нэг.Үндэсний нэгдмэл үнэт зүйл	5	16	-	6	8	2	45.0
2	Хоёр. Хүний хөгжил	7	49	8	22	19	-	68.4
3	Гурав.Амьдралын чанар ба дундаж давхарга	6	27	-	19	8	-	67.8
4	Дөрөв.Эдийн засаг	6	35	13	13	8	1	77.4
5	Тав. Засаглал	6	25	1	13	6	5	61.2
6	Зургаа.Ногоон хөгжил	4	18	1	12	5	-	77.2
7	Долоо.Амар тайван, аюулгүй нийгэм	5	23	3	19	1	-	83.5
8	Найм.Бүс, орон нутгийн хөгжил	3	29	-	14	14	1	50.3
9	Ес. Улаанбаатар ба дагуул хот	5	21	-	8	12	1	50.5
Нийт		47	243	26	126	81	10	67.0
Нийт дүнд эзлэх хувь				10.7	51.9	33.3	4.1	

Дээрх үндсэн 9 бодлогын 2021-2024 оны хэрэгжилтийг 2024 оны дүнтэй харьцуулахад, Үндэсний нэгдмэл үнэт зүйлийн бодлогын хэрэгжилт 6.9 нэгж хувиар, Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хэрэгжилт 11.3 нэгж хувиар, Улаанбаатар ба дагуул хот бодлогын хэрэгжилт 6.7 нэгж хувиар тус тус буурсан бол бусад бодлогын хувьд 1.6-11.3 хүртэл нэгж хувиар өссөн байна.

Зураг 1. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт (үндсэн 9 бодлогоор, 2024 оны болон өссөн дүнгээр)



2.1.Үндэсний нэгдмэл үнэт зүйл

Үндэсний нэгдмэл үнэт зүйл бодлогын хүрээнд “Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн Монгол хүнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ” гэсэн зорилгыг дэвшүүлж, үндэсний бахархал, эв нэгдэл, нүүдлийн соёл иргэншилт монгол, монгол хэл бичиг, эрдэм судлал, нийгмийн соёл гэгээрэл, дэлхийн монгол гэсэн чиглэлийн хүрээнд 5 зорилт, 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр үндсэн чиглэлд тусгасан.

Дээрх зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд, хэрэгжилт дунджаар 45.0 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна. 2024 оны хэрэгжилттэй харьцуулахад, 6.9 хувийн өөрчлөлттэй байна.

Хүснэгт 2. Үндэсний нэгдмэл үнэт зүйл зорилгын хэрэгжилт (хамаарах зорилт, хэрэгжилтийн хувиар)

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь				Дундаж үнэлгээ
			Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
			100.0	90.0-70.0	69.0-30.0	29.0-0.0	
1.1	Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, хамтын үнэт зүйлс, тэмүүлэл, эх оронч үзэл, эв нэгдлийг бэхжүүлнэ.	5	-	4	1	-	66.0
1.2	Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ.	4	-	-	3	1	27.5

1.3	Үндэсний Монгол хэл, бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ.	2	-	-	1	1	15.0
1.4	Үнэт зүйлийн болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлийн судалгааг салбар бүрээр хийж, нийтийн хүртээл болгоно.	2	-	-	2	-	30.0
1.5	Олон улс дахь Монгол үндэсний үнэт зүйлсийн дархлааг бэхжүүлж, монгол соёлын хүрээг тэлнэ.	3	-	2	1	-	63.3
Нийт		16	0	6	8	2	45.0
Нийт дүнд эзлэх хувь			0.0	37.5	50.0	12.5	

Үндэсний нэгдмэл үнэт зүйл бодлого, зорилгын хүрээнд дэвшүүлсэн 5 зорилтын 16 арга хэмжээнээс 2 зорилтын 6 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 5 зорилтын 8 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай”, 2 зорилтын 2 арга хэмжээ “үр дүнгүй” хэрэгжсэн байна.

Дээрх зорилгын хүрээнд хамаарах хяналт-шинжилгээ, үнэлгээний 6 шалгуур үзүүлэлт батлагдсанаас 5 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 100.0 хувь, 1 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 28.2 хувь байна. Шинэ бүтээл, патентын мэдүүлэг, дотоодын мэдүүлэг, 1000 хүн тутамд ногдох соёл, урлагийн байгууллагын суудлын тоо, Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж, Төрийн өмчийн музейн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо, Урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд хүүхдийн эзлэх хувь зэрэг шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 100 хувь байгаа бол бол Номын сангийн нийт сан хөмрөгт цахим сан хөмрөгийн эзлэх хувь өмнөх онд 1.09 байсан бол энэ онд 1.24 болж 13.7 хувиар өссөн хэдий ч 2025 оны хүрэх түвшинг 5 гэж төлөвлөсөн учир буурсан үр дүн харагдаж байна.

2.2.Хүний хөгжил

Хүний хөгжлийн бодлогын хүрээнд “Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ” гэсэн зорилгыг дэвшүүлж, боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, шинжлэх ухаан, инновац, хүнд ээлтэй амьдрах орчин, хөдөлмөрийн зах зээл, монгол хүний удмын сан гэсэн чиглэлийн хүрээнд 7 зорилт, 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Дээрх зорилт, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 68.4 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна. 2024 оны хэрэгжилттэй харьцуулахад, 2.5 хувийн өөрчлөлттэй байна.

Хүснэгт 3. Хүний хөгжил зорилгын хэрэгжилт (хамаарах зорилт, хэрэгжилтийн хувиар)

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь				Дундаж үнэлгээ
			Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
			100.0	90.0-70.0	69.0-30.0	29.0-0.0	
2.1	Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.	12	1	8	3	-	74.2
2.2	Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийнэ.	8	-	4	4	-	60.0

2.3	Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ.	5	-	1	4	-	54.0
2.4	Шинжлэх ухаан, технологийг улс орны тогтвортой хөгжлийн үндсэн хүчин зүйлсийн нэг болгон хөгжүүлж, үр ашигтай үндэсний инновацын тогтолцоог бүрдүүлнэ.	9	5	4	-	-	86.7
2.5	Эрүүл баталгаат орчныг бий болгоно:	6	-	2	4	-	56.7
2.6	Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хэрэгцээнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлнэ.	5	1	3	1	-	72.0
2.7	Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, дэмжинэ.	4	1	-	3	-	57.5
Нийт		49	8	22	19	0	68.4
Нийт дүнд эзлэх хувь			16.3	44.9	38.8	0.0	

Хүний хөгжил бодлого, зорилгын хүрээнд дэвшүүлсэн 7 зорилтын 49 арга хэмжээнээс 4 зорилтын 8 арга хэмжээ нь “үр дүнтэй”, 6 зорилтын 22 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 6 зорилтын 19 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн байна.

Дээрх зорилгын хүрээнд хамаарах хяналт-шинжилгээ, үнэлгээний 30 шалгуур үзүүлэлт батлагдсан ба эдгээр шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин дунджаар 88.1 хувь байна. Нийт шалгуур үзүүлэлтээс 6 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 100.0 хувь, 3 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 70.0-99.0 хүртэл хувь, 4 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 30.0-69.0 хувь, 9 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 0.0 хувь байгаа ба 8 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тооцох боломжгүй байна.

Үндсэн чиглэлд тусгагдсан энэхүү зорилгод хамаарах 49 арга хэмжээний хэрэгжилттэй харьцуулж үзэхэд, шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин нь арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувиас 19.7 нэгж хувиар илүү байна.

- Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин 2019 онд 81.5 хувь байсан бол 2024 оны байдлаар 91.8 хувь болж, 2019 оны суурь түвшнээс 11.3 нэгж хувиар, 2025 оны зорилтот /89.4/ түвшнээс 2.4 нэгж хувиар илүү үзүүлэлттэй байна.

- Дээд боловсролын нийт багшид докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь 2024 онд 45.1 хувьд хүрсэн нь 2025 оны зорилтот түвшингээс 0.1 нэгж хувиар илүү буюу зорилтот түвшинг хангасан байна.

- 2024 оны эхний 11 сарын байдлаар 10,000 хүн амд вируст гепатитын өвчлөлийн тоо 0.5 болж, суурь түвшнээс 2.9 нэгж, 2025 оны зорилтот түвшнээс 2.0 буурсан эерэг үзүүлэлттэй байна.

- Нэг сая хүнд оногдох эрдэм шинжилгээний өгүүллийн тоо, шинэ бүтээлийн гэрчилгээ авсан бүтээлийн тоо, органик, баяжуулсан, зохицуулах үйлчилгээтэй инновац нэвтрүүлсэн шинэ бүтээгдэхүүний тоо зэрэг шалгуур үзүүлэлтийн 2024 оны хүрсэн түвшин нь 100.0 хувь байна.

- Тухайн жилийн товлот дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь, Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь, Тавт вакцины 3 дах тунгийн хамралтын хувь, Улаанбурхан-гахайн хавдар-улаануудын /УГУ/ эсрэг вакцины 2 дах тунгийн хамралтын хувь, Шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь зэрэг шалгуур үзүүлэлтийн 2024 оны хүрсэн түвшин суурь түвшнээс буурсан дүнтэй байна.

2.3.Амьдралын чанар ба дундаж давхарга

Монгол хүний амьдралын чанар ба дундаж давхарга бодлогын хүрээнд “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангах тогтолцоог бий болгож, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ” гэсэн зорилгыг дэвшүүлж, нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл, орлогод нийцсэн орон байр, хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес, дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, газрын харилцаа зэрэг чиглэлийн хүрээнд 6 зорилт, 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Дээрх зорилт, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 67.8 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна. 2024 оны хэрэгжилттэй харьцуулахад, 1.5 хувийн өөрчлөлттэй байна.

Хүснэгт 4. Амьдралын чанар ба дундаж давхарга зорилгын хэрэгжилт (хамаарах зорилт, хэрэгжилтийн хувиар)

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь				Дундаж үнэлгээ
			Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
			100.0	90.0-70.0	69.0-30.0	29.0-0.0	
3.1	Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчилнэ.	5	-	5	-	-	82.0
3.2	Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ.	4	-	2	2	-	60.0
3.3	Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	5	-	2	3	-	58.0
3.4	Дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээг бэхжүүлнэ.	2	-	1	1	-	60.0
3.5	Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ.	5	-	3	2	-	66.0
3.6	Монгол Улсын газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	6	-	6	-	-	73.3
Нийт		27	0	19	8	0	67.8
Нийт дүнд эзлэх хувь			0.0	70.4	29.6	0.0	

Монгол хүний амьдралын чанар ба дундаж давхарга бодлого, зорилгын хүрээнд дэвшүүлсэн 6 зорилтын 27 арга хэмжээнээс 6 зорилтын 19 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 4 зорилтын 8 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн байна.

Дээрх зорилгын хүрээнд хамаарах хяналт-шинжилгээ, үнэлгээний 11 шалгуур үзүүлэлт батлагдсан ба эдгээр шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин дунджаар 100.0 хувь байна. Нийт шалгуур үзүүлэлтээс 5 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 100.0 хувь байгаа бол 6 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тооцох боломжгүй байна.

Үндсэн чиглэлд тусгагдсан энэхүү зорилгод хамаарах 27 арга хэмжээний хэрэгжилттэй харьцуулж үзэхэд, шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин нь арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувиас 32.2 нэгж хувиар бага байна.

2.4.Эдийн засаг

Эдийн засгийн бодлогын хүрээнд “Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, нефть, шатахууны дотоодын хэрэгцээг өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлсэн улс болно” гэсэн зорилгыг дэвшүүлж, чинээлэг монгол, эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд, ухаалаг санхүүгийн зээл, бүс нутгийн хамтын ажиллагаа, өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн, үндэсний баялгийн сан гэсэн чиглэлийн хүрээнд 6 зорилт, 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Дээрх зорилт, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 77.7 хувь буюу тодорхой үр дүнд хүрч хэрэгжсэн байна. 2024 оны хэрэгжилттэй харьцуулахад, 5.1 хувийн өөрчлөлттэй байна.

Хүснэгт 5. Эдийн засаг зорилгын хэрэгжилт (хамаарах зорилт, хэрэгжилтийн хувиар)

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь				Дундаж үнэлгээ
			Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
			100.0	90.0-70.0	69.0-30.0	29.0-0.0	
4.1	Засгийн газрын хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэж, үр ашгийг дээшлүүлж, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлнэ.	7	4	3	-	-	92.9
4.2	Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	16	5	5	6	-	69.4
4.3	Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ.	5	2	1	1	1	69.3
4.4	Хөрш орнуудтай хамтран эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, Евразийн эдийн засгийн холбоо, Бүгд Найрамдах Солонгос Улстай чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулах эсэх талаар урьдчилсан судалгааг эхлүүлнэ.	4	1	3	-	-	90.0
4.5	Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг инновацад тулгуурлан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлнэ.	2	-	1	1	-	76.7
4.6	Баялгийн сан байгуулж, санхүүгийн үр ашигтай төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийнэ.	1	1	-	-	-	100.0
Нийт		35	13	13	8	1	77.7
Нийт дүнд эзлэх хувь			37.1	37.1	22.9	2.9	

Эдийн засгийн бодлого, зорилгын хүрээнд дэвшүүлсэн 6 зорилтын 35 арга хэмжээнээс 5 зорилтын 13 арга хэмжээ “үр дүнтэй”, 5 зорилтын 13 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 3 зорилтын 8 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай”, 1 зорилтын 1 арга хэмжээ “үр дүнгүй” гэж үнэлэгдсэн нь “4.3.3. Бичил санхүүгийн байгууллагуудыг чадавхжуулан эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулж, үйл ажиллагааны хүрээг тэлнэ” гэсэн арга хэмжээ байна.

Дээрх зорилгын хүрээнд хамаарах хяналт-шинжилгээ, үнэлгээний 14 шалгуур үзүүлэлт батлагдсан ба эдгээр шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин дунджаар 54.7 хувь байна. Нийт шалгуур үзүүлэлтээс 2 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 100.0 хувь, 1 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 70.0 хувь, 1 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 50.0 хувь, 2 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 7.9-0.0 хувь байгаа ба 8 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тооцох боломжгүй байна. Үндсэн чиглэлд тусгагдсан тус зорилгод хамаарах 49 арга хэмжээний хэрэгжилттэй харьцуулж үзэхэд, шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин нь арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувиас 23.0 нэгж хувиар бага байна.

2.5.Засаглал

Засаглалын бодлогын хүрээнд “Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.” гэсэн зорилгыг дэвшүүлж, ухаалаг засаглал, ухаалаг бүтэц, цахим монгол, чадварлаг, ёс зүйтэй төрийн алба, хүний эрхийг дээдэлсэн нийгэм, авлигагүй засаглал гэсэн чиглэлийн хүрээнд 6 зорилт, 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Дээрх зорилт, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 60.6 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна. 2024 оны хэрэгжилттэй харьцуулахад, 5.4 хувийн өөрчлөлттэй байна.

Хүснэгт 6. Засаглал зорилгын хэрэгжилт (хамаарах зорилт, хэрэгжилтийн хувиар)

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь				Дундаж үнэлгээ
			Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
			100.0	90.0-70.0	69.0-30.0	29.0-0.0	
5.1	Эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэртэй байдал, түүнд тавих хяналтыг оновчтой болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, тогтвортой, хяналттай засаглалыг төлөвшүүлнэ.	4	-	2	2	-	75.0
5.2	Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх мэдлийн зааг, ялгааг оновчтой тодорхойлж, оролцоог зохистой хангасан, иргэдээ сонсдог, хувийн хэвшилтэйгээ хамтарч ажилладаг тогтолцоог бий болгоно.	3	1	2	-	-	87.8
5.3	Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлнэ.	4	-	4	-	-	86.6
5.4	Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.	7	-	3	2	2	47.1
5.5	Хүний эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт түншлэлийг хөгжүүлнэ.	4	-	1	-	3	21.7
5.6	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон	3	-	1	2	-	63.3

бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлнэ.						
Нийт	25	1	13	6	5	60.6
Нийт дүнд эзлэх хувь		4.0	52.0	24.0	20.0	

Засаглалын бодлого, зорилгын хүрээнд дэвшүүлсэн 6 зорилтын 25 арга хэмжээнээс 1 зорилтын 1 арга хэмжээ “үр дүнтэй”, 6 зорилтын 13 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 3 зорилтын 6 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай”, 2 зорилтын 5 арга хэмжээ “үр дүнгүй” гэж үнэлэгдсэн байна.

Дээрх зорилгын хүрээнд хамаарах хяналт-шинжилгээ, үнэлгээний 6 шалгуур үзүүлэлт батлагдсан ба эдгээр шалгуур үзүүлэлтээс Цахим засгийн хөгжлийн үзүүлэлтийн хүрсэн түвшин 100.0 хувь бөгөөд Дэлхийн банкны үндсэн шалгуурын хүрээнд тооцож гаргадаг засаглалын 5 үзүүлэлтийн 2024 оны мэдээлэл гарах хугацаа болоогүй тул үнэлэх боломжгүй байна.

2.6.Ногоон хөгжил

Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд “Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана” гэсэн зорилгыг дэвшүүлж, эх байгаль анхдагч экосистем, байгалийн баялгийн үр өгөөж, үнэт баялаг ус, нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил гэсэн чиглэлийн хүрээнд 4 зорилт, 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Дээрх зорилт, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 75.2 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна. 2024 оны хэрэгжилттэй харьцуулахад, 11.3 хувийн өөрчлөлттэй байна.

Хүснэгт 7. Ногоон хөгжил зорилгын хэрэгжилт (хамаарах зорилт, хэрэгжилтийн хувиар)

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь				Дундаж үнэлгээ
			Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
			100.0	90.0-70.0	69.0-30.0	29.0-0.0	
6.1	Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эх зэрэг онцлог экосистем бүхий газар нутгийг судалж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэн эдийн засгийн үр өгөөжийг үнэлнэ.	2	-	1	1	-	66.7
6.2	Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохимжтой ашиглах, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомсдолыг бууруулах, ашиглалтын нөөц бий болгоно.	5	1	4	-	-	89.3
6.3	Усны хуримтлал, ус хангамжийг нэмэгдүүлж, усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах нэгдсэн менежментийг хэрэгжүүлнэ.	4	-	3	1	-	68.3
6.4	Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай цэвэр технологи нэвтрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтийг	7	-	4	3	-	71.4

сааруулах, дасан зохицох үндэсний чадавхыг бүрдүүлнэ.						
Нийт	18	1	12	5	0	75.2
Нийт дүнд эзлэх хувь		5.6	66.7	27.8	0.0	

Ногоон хөгжлийн бодлого, зорилгын хүрээнд дэвшүүлсэн 4 зорилтын 18 арга хэмжээнээс 1 зорилтын 1 арга хэмжээ “үр дүнтэй”, 4 зорилтын 12 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 3 зорилтын 5 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай” үнэлэгдсэн байна.

Дээрх зорилгын хүрээнд хамаарах хяналт-шинжилгээ, үнэлгээний 13 шалгуур үзүүлэлт батлагдсан ба эдгээр шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин дунджаар 69.0 хувь байна. Нийт шалгуур үзүүлэлтээс 5 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 100.0 хувь, 2 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 70.0-90.0 хүртэл хувь, 1 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 30.0 хувь, 2 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 0.0 хувь байгаа ба 3 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тооцох боломжгүй байна. Үндсэн чиглэлд тусгагдсан “Ногоон хөгжил” зорилгод хамаарах 18 арга хэмжээний хэрэгжилттэй харьцуулж үзэхэд, шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин нь арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувиас 6.2 хувиар бага байна.

2.7.Амар тайван, аюулгүй нийгэм

Амар тайван, аюулгүй нийгэм бодлогын хүрээнд “Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана” гэсэн зорилгыг дэвшүүлж, энэ хүрээнд 5 зорилт, 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Дээрх зорилт, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 83.3 хувь буюу “тодорхой үр дүнтэй” хэрэгжсэн байна. 2024 оны хэрэгжилттэй харьцуулахад, 1.6 хувийн өөрчлөлттэй байна.

Хүснэгт 8. Амар тайван, аюулгүй нийгэм зорилгын хэрэгжилт (хамаарах зорилт, хэрэгжилтийн хувиар)

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь				Дундаж үнэлгээ
			Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
			100.0	90.0-70.0	69.0-30.0	29.0-0.0	
7.1	Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ.	4	-	4	-	-	75.0
7.2	Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлэн холбоо, зэвсэглэл, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлнэ.	4	1	3	-	-	87.5
7.3	Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	6	-	5	1	-	80.0
7.4	Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчин, материаллаг баазыг бэхжүүлнэ.	7	2	5	-	-	86.7

7.5	Кибер аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, технологид суурилсан инновац, интеграцыг хөгжүүлж, эрсдэлийн менежментийн үндэсний чадавхыг бэхжүүлнэ.	2	-	2	-	-	90.0
Нийт		23	3	19	1	0	83.3
Нийт дүнд эзлэх хувь			13.0	82.6	4.3	0.0	

Амар тайван, аюулгүй нийгэм бодлого, зорилгын хүрээнд дэвшүүлсэн 5 зорилтын 23 арга хэмжээнээс 2 зорилтын 3 арга хэмжээ “үр дүнтэй”, 5 зорилтын 19 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 1 зорилтын 1 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай” үнэлэгдсэн байна.

Дээрх зорилгын хүрээнд хамаарах хяналт-шинжилгээ, үнэлгээний 3 шалгуур үзүүлэлт батлагдсан ба эдгээрээс Дэлхийн энх тайвны үзүүлэлт, "Оюутан цэрэг" сургалтад хамрагдах суралцагчдын тоо гэсэн шалгуур үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрээгүй буюу суурь түвшнээс буурсан үзүүлэлттэй, харин Даяаршлын үзүүлэлтийн хүрсэн түвшинг тооцох боломжгүй байна.

2.8.Бүс, орон нутгийн хөгжил

Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд “Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлнэ” зорилгыг дэвшүүлж, энэ хүрээнд дэд бүтэц, аялал жуулчлал, тогтвортой хөдөө аж ахуй гэсэн 3 зорилт, 29 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Дээрх зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд, хэрэгжилт дунджаар 50.3 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна. 2024 оны хэрэгжилттэй харьцуулахад, 11.4 хувийн өөрчлөлттэй байна.

Хүснэгт 9. Бүс, орон нутгийн хөгжил зорилгын хэрэгжилт (хамаарах зорилт, хэрэгжилтийн хувиар)

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь				Дундаж үнэлгээ
			Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
			100.0	90.0-70.0	69.0-30.0	29.0-0.0	
8.1	Эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбоно.	11	-	5	6	-	50.0
8.2	Үндэсний онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	3	-	-	2	1	20.0
8.3	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ.	15	-	9	6	-	56.7
Нийт		29	0	14	14	1	50.3
Нийт дүнд эзлэх хувь			0.0	48.3	48.3	3.4	

Бүс, орон нутгийн хөгжил бодлого, зорилгын хүрээнд дэвшүүлсэн 3 зорилтын 29 арга хэмжээнээс 2 зорилтын 14 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 3 зорилтын 14 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай”, 1 зорилтын 1 арга хэмжээ “үр дүнгүй” гэж үнэлэгдсэн байна.

Үр дүнгүй гэж үнэлэгдсэн “8.2.3 Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг Хөвсгөл, Хэнтий, Архангай, Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан зэрэг аймагт хэрэгжүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын орлогыг нэмэгдүүлнэ.” арга хэмжээ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан боловч ТЭЗҮ, үзэл баримтлалын асуудал УИХ-ын Байнгын хорооны хурлаар орж дэмжигдээгүй тул Азийн хөгжлийн банкнаас тус төслийг цаашид хэрэгжүүлэхгүй гэсэн шийдвэрийг гаргасантай холбоотойгоор тус төсөл хэрэгжээгүй байна.

Дээрх зорилгын хүрээнд хамаарах хяналт-шинжилгээ, үнэлгээний 8 шалгуур үзүүлэлт батлагдсан ба эдгээр шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин дунджаар 68.7 хувь байна. Нийт шалгуур үзүүлэлтээс 4 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 100.0 хувь, 1 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 96.0 хувь, 1 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 53.4 хувь, 2 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 0.0 хувь байна. Үндсэн чиглэлд тусгагдсан “Бүс, орон нутгийн хөгжил” зорилгод хамаарах 29 арга хэмжээний хэрэгжилттэй харьцуулж үзэхэд, шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин нь арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувиас 18.4 хувиар илүү байна.

2.9.Улаанбаатар ба дагуул хот

Улаанбаатар ба дагуул хот бодлогын хүрээнд “Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ” гэсэн зорилгыг дэвшүүлж, хүн төвтэй хот, орчин төвтэй шийдэл, төлөвлөлт төвтэй хөгжил, хотын сайн засаглал, дагуул хот гэсэн чиглэлийн хүрээнд 5 зорилт, 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр үндсэн чиглэлд тусгасан.

Дээрх зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд, дунджаар 50.5 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна. 2024 оны хэрэгжилттэй харьцуулахад, 6.6 хувийн өөрчлөлттэй байна.

Хүснэгт 10. Улаанбаатар ба дагуул хот зорилгын хэрэгжилт (хамаарах зорилт, хэрэгжилтийн хувиар)

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь				Дундаж үнэлгээ
			Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
			100.0	90.0-70.0	69.0-30.0	29.0-0.0	
9.1	Нийгмийн дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	3	-	2	1	-	76.7
9.2	Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангаж, нөхөн сэргээх, харицлагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгоно.	4	-	2	1	1	47.5
9.3	Хотын төвлөрлийг задалж дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ухаалаг технологийн шинэчлэл хийнэ.	5	-	1	4	-	38.0
9.4	Хууль, эрх зүйн шинэчлэл хийж, хотын засаглал, эдийн засаг, нийгмийн таатай орчныг бүрдүүлнэ.	3	-	2	1	-	70.0
9.5	Хөрөнгө оруулалтын шинэ боломж бүрдүүлж, үйлдвэрлэлийн бүс нутгийг тэлнэ.	6	-	1	5	-	40.0
Нийт		21	0	8	12	1	50.5
Нийт дүнд эзлэх хувь			0.0	38.1	57.1	4.8	

Улаанбаатар ба дагуул хот бодлого, зорилгын хүрээнд дэвшүүлсэн 5 зорилтын 21 арга хэмжээнээс 5 зорилтын 8 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 5 зорилтын

хэрэгжилт 12 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай”, 1 зорилтын 1 арга хэмжээ “үр дүнгүй” үнэлэгдсэн байна.

Дээрх зорилгын хүрээнд хамаарах хяналт-шинжилгээ, үнэлгээний 3 шалгуур үзүүлэлт батлагдсан ба эдгээр шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин дунджаар 13.5 хувь байна. Нийт шалгуур үзүүлэлтээс “Хотын хөгжлийн үзүүлэлт” шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 40.6 хувь, “Улаанбаатар хотын агаар дахь РМ 2.5 тоосонцрын 2024 оны жилийн дундаж агууламж”, “Улаанбаатар хотын агаар дахь РМ10 тоосонцрын жилийн дундаж агууламж” шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 0.0 хувь байна. БОУАӨЯ-ны <http://agaar.mn/> цахим хуудсан дах агаарын чанарын хяналт шинжилгээний сар бүрийн тойми мэдээллээс харахад, РМ2.5 тоосонцрын дундаж агууламж 2024 оны 11, 12 дугаар сарын дунджаар 71 мкг/м3, РМ10 тоосонцрын дундаж агууламж 2024 оны 11, 12 дугаар сарын дунджаар 121 мкг/м3 байгаа нь шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшнээс өндөр байна.

Дөрөв.Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг баталсан ба үүнд нийт 95 шалгуур үзүүлэлт, түүний суурь түвшинг 2018, 2019, 2020 оны байдлаар, хүрэх түвшинг 2025 оноор тодорхойлж баталсан. Мөн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх 82 шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах давтамжийг жилд 1 удаа, 5 шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах давтамжийг 5 жилд 1 удаа, 4 шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах давтамжийг 2 жилд 1 удаа, 2 шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах давтамжийг улирал бүр байхаар тус тус тодорхойлж баталсан бөгөөд 2 шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах давтамжийг тодорхойлоогүй байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний 94¹ шалгуур үзүүлэлтийн 26.6 хувь буюу 25 нь улсын хөгжлийг тодорхойлох ерөнхий үзүүлэлтүүд байгаа бол 73.4 хувь буюу 69 нь салбарын, байгууллагын, нутаг дэвсгэрийн хүрээний үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой үзүүлэлтүүд байна.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшингийн мэдээллийг “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3в хавсралтын дагуу нэгтгэн гаргасан ба ингэхдээ шалгуур холбогдох төрийн захиргааны байгууллагын мэдээлэл болон Үндэсний статистикийн газрын статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэсэн.

Нийт 94 шалгуур үзүүлэлтээс 63 үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлсон ба 31 шалгуур үзүүлэлтийн тайлагнах хугацаа болоогүй тул хүрсэн түвшинг тодорхойлох боломжгүй байна. Дээрх 63 шалгуур үзүүлэлтийн 29.8 хувь буюу 28 үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрсэн, 7.4 хувь буюу 7 үзүүлэлт 70.0 дээш хувиар зорилтот түвшинг хангасан бол 29.8 хувь буюу 28 шалгуур зорилтот түвшингээ хангаагүй байна.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүнг тодорхойлоход хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг ашиглаж байгаа бөгөөд батлагдсан шалгуур үзүүлэлтийг үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээтэй харьцуулан авч үзэхэд, ямар түвшний үр дүнг хэмжих гэж байгаа нь зарим талаар тодорхой бус, тухайн шалгуур үзүүлэлт нь тухайн чиглэлийн зорилт, арга хэмжээтэй нийцтэй бус буюу тухайн арга хэмжээг хэрэгжүүлснээр шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшин, үр дүн бүрэн хангагдах эсэх нь эргэлзээтэй, зорилт,

¹ Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд тусгагдсан 15 болон 18 дахь “Бүлэг дүүргэлт (боловсролын бүх түвшинээр)” шалгуур үзүүлэлт давхцаж байгаа болно.

арга хэмжээний болон шалгуур үзүүлэлтийн хамаарал, нөлөөллийг тодорхойлоогүй зэрэг асуудлууд байгаа нь шалгуур үзүүлэлтэд үндэслэн үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүнг шууд тодорхойлох боломжгүй болгож байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2021-2024 оны хэрэгжилт дунджаар 67.0 хувь байна. “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3-д заасан ангилалд шилжүүлэн тооцвол, нийт арга хэмжээний 10.7 хувь буюу 26 арга хэмжээ “үр дүнтэй”, 51.9 хувь буюу 126 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 33.3 хувь буюу 81 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай”, 4.1 хувь буюу 10 арга хэмжээ “үр дүнгүй хэрэгжсэн байна.

Хүснэгт 14. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнгийн ангиллаар

Ангилал	Үнэлгээ	Арга хэмжээний тоо	Нийт дүнд эзлэх хувь
Үр дүнтэй	100%	26	10.7
Тодорхой үр дүнд хүрсэн	70-99%	126	51.9
Эрчимжүүлэх шаардлагатай	30-69%	81	33.3
Үр дүнгүй	0-29%	10	4.1
Нийт дүн		243	100.0

“Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын I үе шатны болон Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилго, зорилтын тухайн таван жилд хүрэх үр дүн, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, тухайн шалгуур үзүүлэлтээр хэмжих зорилтот түвшинг он тус бүрээр тодорхойлоогүй тул Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.3-т заасан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилт, үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг илэрхийлэх боломжгүй байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.1-д заасан “хөгжлийн бодлогын зорилго, зорилтын тухайн таван жилд хүрэх үр дүн, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, тухайн шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх зорилтот түвшинг тодорхойлсон байх” гэсэн заалт хэрэгжээгүй буюу Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээний зорилтот түвшингийн шалгуур үзүүлэлтийг он тус бүрээр тодорхойлоогүй байгаа нь жил бүр хэрэгжилтийн явц, үр дүнг тооцоход хүндрэл учруулж байна.

Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төлөвлөлтийн баримт бичиг нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө бөгөөд Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд дээрх үндсэн чиглэлийн 62 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг тусгасан байна. Энэ нь үндсэн чиглэлд тусгагдсан нийт зорилт, арга хэмжээний 25.5 хувийг эзэлж байгаагаас үзэхэд, үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилт жил бүр хэрэгжих боломжгүй байх, тухайн жилд шаардлагатай санхүүжилт батлагдахгүй байх, үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүнг жил бүр бодитой үнэлж дүгнэх нөхцөл бүрдэхгүй байх зэрэг асуудлуудыг үүсгэж байна.

Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл тусгагдсан зорилт, арга хэмжээний санхүүжилтийг тухайн жилийн улсын төсөвт тусгаж байхаар заасны дагуу үндсэн чиглэл болон Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсвийн уялдаа, хамаарлыг бодитой, оновчтой төлөвлөж, санхүүжилтийн гүйцэтгэлийг бодлогын баримт бичиг тус бүрээр бодитой тооцож, үнэлэх шаардлагатай байна.

Түүнчлэн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.5-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх” гэж заасны дагуу төрийн захиргааны төв байгууллагууд үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг бусад төлөвлөлт, төсөвлөлтийн баримт бичгүүдтэй уялдуулж, он тус бүрээр шалгуур үзүүлэлттэйгээр баталж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2024 оны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн цаашид дараах асуудалд анхаарч ажиллахыг Зөвлөмж болгож байна. Үүнд:

1.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийг сайжруулах хүрээнд:

1.1.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.5-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх” гэж заасны дагуу үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг бусад төлөвлөлтийн баримт бичгүүдтэй уялдуулж, он тус бүрээр шалгуур үзүүлэлттэйгээр баталж, хэрэгжүүлэх;

1.2.Хөгжлийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөлтийн явцад урьдчилсан үнэлгээ хийж, хөгжлийн бодлого, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг өнөөгийн бодит нөхцөл байдалд тулгуурлан оновчтой төлөвлөж байгаа эсэх, дунд, богино хугацаанд улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд бодлогын төлөвлөлт харилцан уялдаатай байгаа эсэх, бодлогын хэрэгжилт, үр дүнг тодорхойлох шалгуур үзүүлэлт оновчтой эсэхийг тодорхойлж, төлөвлөлтийн алдаа гаргахгүй байхад анхаарч ажиллах;

1.3.Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөвлөлтийн шинжилгээг хийж, төсөв хөрөнгийг жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөвт тусгах саналыг хүргүүлж, санхүүжилтийн эх үүсвэрүүдийг шийдүүлж, хэрэгжүүлэх;

1.4.Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг бэхжүүлэх хүрээнд урт, дунд, богино хугацааны бодлогын төлөвлөлт, төсөвлөлт, мониторинг, үнэлгээ хийх эрх зүйн орчныг бүрдүүлж, нэгдсэн удирдлагын системийг хөгжүүлэх;

1.5.Хөгжлийн бодлогын дунд хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах аргачлал, бодлогын өртөг тооцох аргачлалыг баталж мөрдүүлэх;

1.6. Хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дагавар, үр нөлөөг үндэсний, салбарын, орон нутгийн түвшинд тодорхойлох үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн сан бий болгож, төлөвлөлт болон хяналт, шинжилгээ, үнэлгээнд ашиглах;

2.Хөгжлийн бодлого, арга хэмжээг үр дүнд чиглүүлэн удирдан зохион байгуулах

2.1.Хөгжлийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад байнгын хяналт-шинжилгээ хийж, төлөвлөсөн үр дүнд чиглүүлэн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

2.2.Бодлого, арга хэмжээний үндсэн хэрэгжүүлэгч байгууллага нь тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хамтрагч байгууллагуудыг удирдлага,

зохион байгуулалтаар хангаж, үр дүнтэй хамтран ажиллах, эргэх уялдаа холбоог сайжруулах, үр дүнг нэгтгэн тайлагнах;

3.Бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайлагналыг сайжруулах хүрээнд:

3.1.Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилттэй уялдуулан тайлагнаж, бодлогын үр дүн, үр нөлөөг үнэлж, дүгнэж байх;

3.2.Бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилт, хэрэгжилтийн хүрсэн үр дүнг бүрэн, тодорхой тайлагнаж, нотлох баримтад тулгуурласан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх боломжийг бүрдүүлэх;

3.3.Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага тухайн арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, санхүүжилтийн гүйцэтгэлийг нэгтгэн тайлагнах;

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн гүйцэтгэлийн тайлантай дараах (QR) кодоор нэвтрэн танилцана уу.



----- оОо -----